



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 738

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хил хамгаалах ерөнхий газрын харьяа хилийн анги, тусгай салбарын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 2627 нэрийн нийт 6,122,506,283.76 (зургаан тэрбум нэг зуун хорин хоёр сая таван зуун зургаан мянга хоёр зуун наян гурван төгрөг далан зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 2,965,580,107.91 (хоёр тэрбум есөн зуун жаран таван сая таван зуун наян мянга нэг зуун долоон төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Хил хамгаалах ерөнхий газрын ар тал, зэвсэглэл, инженер техник эрхэлсэн дэд дарга хурандаа Д.Ганбаатар, Хилийн анги, тусгай салбарын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.Нарангэрэл Д.НАРАНГЭРЭЛ

13201713

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 12
дугаар сарын 31 ний өдрийн 738
дугаар тогтоолын хавсралт

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХИЛИЙН АНГИ,
ТУСГАЙ САЛБАРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ АШИГЛАЛТЫН
ХУГАЦАА СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ
ХӨРӨНГИЙН ДҮН

№	Анги	Нэр төрөл	Балансын үнэ Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Шинээр тогтоосон үнийн дүн /төгрөг/
1	Хилийн 0168-р анги	296	681,728,848.61	484,749,200.00
2	Хилийн 0218-р анги	19	211,805,974.50	104,886,000.00
3	Хилийн 0224-р тусгай салбар	54	150,263,759.07	72,305,615.00
4	Хилийн 0253-р анги	96	261,785,854.43	60,794,500.00
5	Хилийн 0275-р анги	9	9,373,866.85	4,835,000.00
6	Хилийн 0285-р анги	105	72,131,991.70	47,695,000.00
7	Хилийн 0303-р тусгай салбар	51	498,323,214.45	224,680,000.00
8	Хилийн 0311-р анги	57	28,635,519.14	17,362,700.00
9	Хилийн 0151-р анги	310	387,083,480.01	194,513,489.00
10	Хилийн 0164-р анги	47	81,460,032.41	44,595,014.58
11	Хилийн 0208-р тусгай салбар	7	66,916,550.85	24,340,000.00
12	Хилийн 0245-р анги	36	242,712,027.88	83,690,000.00
13	Хилийн 0219-р анги	52	83,013,272.74	60,624,600.00
14	Хилийн 0130-р анги	150	99,418,666.34	66,068,539.33
15	Хилийн 0131-р анги	48	214,246,304.40	90,614,000.00
16	Хилийн 0198-р анги	131	208,398,970.22	62,235,000.00
17	Хилийн 0214-р анги	24	183,133,633.39	84,954,000.00
18	Хилийн 0286-р анги	45	105,586,340.63	40,782,000.00
19	Хилийн 0287-р анги	137	65,052,278.73	41,500,450.00
20	Хилийн 0288-р анги	50	17,673,880.00	13,261,600.00
21	Хилийн 0306-р анги	41	56,655,760.88	28,120,000.00
22	Хилийн 0165-р анги	158	135,066,062.61	123,757,900.00
23	Хилийн 0132-р анги	51	384,031,399.99	104,610,000.00
24	ХҮА	44	29,745,827.00	18,885,000.00

25	Хилийн 0257-р анги	47	220,230,181.01	83,770,000.00
26	Хилийн 0166-р анги	58	304,155,181.20	71,618,500.00
27	Хилийн 0243-р анги	96	205,375,063.26	45,337,600.00
28	Хилийн 0101-р анги	130	243,165,773.87	172,000,000.00
29	Хилийн 0184-р анги	36	212,156,215.24	192,151,500.00
30	Хилийн 0146-р анги	75	259,842,230.00	107,045,000.00
31	Хилийн 0108-р анги	17	102,012,492.00	29,584,500.00
32	Хилийн 0277-р анги	111	271,156,271.31	141,276,400.00
33	Хилийн 0252-р анги	39	30,169,359.04	22,937,000.00
Нийт дүн		2627	6,122,506,283.76	2,965,580,107.91
			/зургаан тэрбум нэг зуун хорин хоёр сая таван зуун зургаан мянга хоёр зуун наян гурван төгрөг далан зургаан мөнгө/	/хоёр тэрбум есөн зуун жаран таван сая таван зуун наян мянга нэг зуун долоон төгрөг ерэн нэгэн мөнгө/